Батлав. "Багануурын дулааны станц" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал

Б. Ариун-Эрдэнэ

УЛААНБААТАР ХОТ
БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК
2725060005
2688794 Д. ХНТ9684

Ажлын нэр: **"Станцын үндсэн тоноглолуудад ША-нд ажиллах горим тогтоох, горимын карт боловсруулах" зөвлөх үйлчилгээний**

АЖЛЫН ДААЛГАВАР

Ажлын зорилго: "Багануурын дулааны станц" ТӨХК-ийн үндсэн тоноглол болох, галын хотлыг нь "НТБҮШ"-ийн горимд бүрэн шилжүүлсэн "КВТС-20-150" зуухнуудын ША(шуурхай ажиллагаа)-ны үед мөрдөх, батлагдсан **"ҮНДСЭН ТОНОГЛОЛЫН ГОРИМЫН КАРТ"** боловсруулж захиалагчид хүлээлгэн өгөх цогц ажил болно.

Ажлын зорилгыг гүйцэтгэхийн тулд дараах ажлуудыг зайлшгүй албан ёсоор гүйцэтгэсэн байх: Тус станцын, энэхүү үйл ажиллагаанд хамрах зуухан төхөөрөмжүүдийн дулаан техникийн туршилт гүйцэтгэсний үндсэн дээр тухайн үндсэн тоноглолуудын голлох суурь үзүүлэлтүүдийг тодорхойлох. Үүнд:

1. Тухайн зуухны дулааны энерги үйлдвэрлэлийн хүчин чадал
2. Түлшний цагийн бодит зарцуулалт
3. Жишмэл түлшний хувийн зарцуулалт (ЖТХЗ)
4. Тухайн зуухны ашигт үйлийн коэффицент (АҮК)
5. Зуухнаас гарч буй утааны хийн бүтэц
6. Бусад холбогдох үзүүлэлтүүдийг тодорхойлох ажлыг тус тус хийх.

Үүний тулд дээрх үзүүлэлтүүдийг онолын тооцоогоор гарсан, бусад холбогдох онолын тооцоолол бүрийн гүйцэтгэлийг ажлын тайланд дэлгэрэнгүйгээр нь тодорхой тусгасан байх.

Уг ажилд хамрагдах үндсэн тоноглолуud: Тус станцын, өнөөгийн байдлаар ША-нд голлон ажиллаж буй, сүүлийн жилүүдэд их засварт орж техник технологийн өөрчлөлтөд хамрагдсан **К-5 зуух, К-6 зуух, К-7 зуух, К-11** зуух тус тус болно.

Туршилт судалгааны ажлын хөтөлбөр, үе шатууд: Үндсэн тоноглолд ША-нд мөрдөх горим тогтоох, карт үйлдэх ажлын явцад туршилт судалгааны ажлыг гүйцэтгэх хөтөлбөр гаргаж, үе шатыг дараах байдлаар явуулсан байна. Үүнд:

А/. Бэлтгэл ажил.

Б/. Туршилт судалгаа, хэмжилтийн ажил

В/. Туршилт, хэмжилтийн үр дүнг нарийвчлан боловсруулах. Эдгээр хөтөлбөр, үе шатны ажлын гүйцэтгэлийг ажил гүйцэтгэлийн ерөнхий тайланд дэлгэрэнгүй тусгасан байна.

Үндсэн ажлын гүйцэтгэл: К-5 зуух, К-6 зуух, К-7 зуух, К-11 зуухан төхөөрөмжүүдийн их, дунд, бага ачааллаар тоноглол бүрийн туршилт, хэмжилт явуулж үр дүнг дэлгэрэнгүй тайлбартайгаар тайланд тусгах. Үүнд үндэслэн дээрх зуухан төхөөрөмжүүдийн ША-нд мөрдөх горимын картыг тоноглол тус бүрд нь гаргаж, баталгаажуулсан байх.

Ажлын гүйцэтгэлийн дүгнэлт, зөвлөмж өгөх: Үндсэн тоноглолын шуурхай ажиллагааны дүгнэлтийг дэлгэрэнгүй бичсэн байх. Харин гүйцэтгэсэн ажилтай холбогдох зөвлөмжийг дараах 2 чиглэлээр өгч, тайланд дурьдсан байна. Үүнд:

1. Горимын карт боловсруулсан үндсэн тоноглолуудтай холбогдох байдлаар.
2. Нийт дулааны станцын технологи схемийн ША-ны талаар тус тус байна.

Бусад холбогдох үйл ажиллагаа: Энэхүү тус Дулааны станцын үндсэн тоноглолд ША-ны туршилт тохируулга хийх, горим тогтоох, горимын карт үйлдэх энэ ажиллагаанд үйлдвэрлэл дотор гүйцэтгэх ажиллагаанд гүйцэтгэгч захиалагч тал хамтарч ажиллана. Тус тусын хариуцан гүйцэтгэх үүргийг, гүйцэтгэгч тал тусад нь төлөвлөж, захиалагч талд танилцуулан зөвшилцөх байдлаар шийднэ.

Гүйцэтгэгч тал холбогдох баримт бичигт тусгасан хугацаанд багтааж, ажлын дэлгэрэнгүй тайлангийн эх хувийг 3 дэвтэрийг захиалагч талд хүлээлгэж өгнө.

Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар боловсруулсан:

Ашиглалтын инженер Н.Базарсад

Горим тооцооны инженер Э.Сэлэнгэ

Хянасан:

"БНДС" ТӨХК-ийн Ерөнхий инженер А. Лхамсүрэн.